



ХҮНИЙ ЭРХИЙН ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГУУДЫН ФОРУМД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗАР**

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Партизаны гудамж, Утас: 26 35 64, Факс: (976-11) 32 49 77,
И-мэйл: doc@nema.mn, Вэбсайт: www.nema.mn

2020.05.13 № 1/212
танай _____ -ны № _____ -т

Саналын хариу хүргүүлэх тухай

Танай форумаас 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр Монгол Улсын Шадар сайдын нэр дээр ирүүлсэн “Коронавируст халдварт (Ковид-19)-ын цартахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай”, “Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгуулах 18 саналыг УИХ-аас томилогдсон ажлын хэсэг дээр хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:

1. Коронавируст халдварт (Ковид-19)-ын цартахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөлд ирүүлсэн саналуудыг УИХ-ын гишүүн Т.Аюурсайханаар ахлуулсан ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын зарим гишүүд, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын зөвлөлөөс ирүүлсэн саналуудын хамт хэлэлцэж, холбогдох саналыг хуулийн төсөлд тусган 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.

2. Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ирүүлсэн саналыг УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнээр ахлуулсан ажлын хэсэг хэлэлцэж, холбогдох саналыг уг хуулийн төсөлд тусгасан болно.

Хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох, хуулт ёсны зарчмыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах, хэвлэл, мэдээллийн хараат бус байдлыг хангах чиглэлээр үнэтэй санал, шүүмж ирүүлсэн Та бүхэнд талархаж, ажлын амжилт хүсье.

Хувийг: Монгол Улсын Шадар сайдын Ажлын албанд

Хүндэтгэсэн,

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Т.БАДРАЛ



00001316

ТАХЛ ФОРСЮЕ
ҮНЭ ТӨЛӨГДСӨН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗАР**

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Партизаны гудамж, Утас: 263564 Факс: 324977
E-mail: doc@nema.mn, http://www.nema.mn
№ 1/12/12
20 оны сарын ондөр

МОНГОЛ ШУУДАН



RD146683683MN



*Дүүрэгийн хувь нийтийн
байгуулалтуудын зорилтууд
СОД ОР дараа. Биеийн тогтолцуу
Нийр дээр 204 тоот.
99 #5828.*